

БАТЛАВ

ХАЛДВАРТ ЭВНИЙ СУДАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГА



Д.НЯМХҮҮ

БАТЛАВ

1116228462
"МОНХАНАНД" ХХК-НИЙ
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

№ 17/21

Улаанбаатар хот

2017 оны 06 дугаар
Сарын 02-ны өдөр

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээ нэг талаас "Мөнх Ананд" ХХК РД:6093582-ийг төлөөлж Захирал албан тушаалтай М.Баярмөнх (цаашид Худалдагч гэх), нөгөө талаас "ХӨСҮТ" (цаашид Худалдан авагч гэх), (хамтад нь талууд гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 243-261-р зүйлийг удирдлага болгон дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцон энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээний зорилго: Энэхүү гэрээгээр Эмнэлгийн хангамжийн материал оршино.
- 1.3 Гэрээний хугацаа: 2017 оны 06 сарын 01-ний өдрөөс эхэлж 2018 оны 06 сарын 01-ний өдөр хүртэл хүчинтэй.

Хоёр. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 2.1 Гэрээний зүйл: Нийлүүлэгч тал нь стандартын шаардлага бүрэн хангасан Мэс заслын халад, хослол, даавуу, Эмч, сувиллагчийн халад, хослол /цаашид бараа гэх/ нийлүүднэ.
- 2.2 Баталгаат хугацаа: Нийлүүлэгч тал нийлүүлж буй бараа бүтээгдэхүүнд чанарын баталгааг гаргах бөгөөд хугацаа ашиглалтын талаар зааварчилгаа өгнө.
- 2.3 Гэрээний үнэ: Барааны үнэ хавсралт-1 д заасан үнэ байна. Гэрээний хавсралт гэрээний адил хүчин төгөлдөр байна.

Гурав. ХУДАЛДАГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Нийлүүлэгч тал нь биет байдлын доголдолгүй, чанарын зөрчилгүй бараа бүтээгдэхүүнийг тогтоосон хугацаанд нийлүүднэ.
- 3.2 Өнгө үзэмж, чанар байдлаа алдсан барааг нийлүүлэгч байх үүрэгтэй.
- 3.3 Бараа бүтээгдэхүүнийг хадгалах, тааварлах, шилжлэл, баталгаат хугацаа, үйлдвэрлэгчидтэй холбогдсон үнэн зөв мэдээлэлийг худалдан авагч талд өгөх үүрэгтэй.

3.4 Худалдаж буй бараа бүтээгдэхүүний чанар стандарт, мөрдөж буй эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан тухай албан ёсны баримт бичгийг борлуулагч талд өгөх үүрэгтэй.

3.5 Нийлүүлсэн бараа бүтээгдэхүүний төлбөр тооцоог нэхэмжлэх эрхтэй.

3.6 Худалдан авагч тал гэрээний үүргээ удаа дараа зөрчсөн тохиолдолд гэрээг дангаар цуцалж, гарсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.

Дөрөв. ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.

4.2 Бараа бүтээгдэхүүнийг хүлээн авахдаа нэр төрөл, тоо ширхэг, жин хэмжээ, сав баглаа боодол, үнийг дагалдах санхүүгийн баримттай тулган холбогдох баримт бичгүүдийг бүрдүүлэн гарын үсгээр баталгаажуулж хүлээн авах үүрэгтэй.

4.3 Бараа бүтээгдэхүүний төлбөр тооцоог гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй.

4.4 Хүлээн авсаны бараа бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан агуулах байранд хадгална. Хадгалалтын горим зөрчсөн байранд хадгалсанаас үүсэх хариуцлагыг хүлээх үүрэгтэй.

4.5 Бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах үед бараа бүтээгдэхүүний доголдолыг мэдсэн буюу мэдэх боломжтой байхад түүнийг хүлээн авсан бол хожим үүсэх хохиролыг нэхэмжлэх эрхгүй.

4.6 Худалдан авагч тал хамтын ажиллагааны явцад олж мэдсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны талаархи мэдээллийг чандлан нууцлах үүрэгтэй.

4.7 Гэрээнд заасан нөхцөлүүдийн талаар өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.

Тав. ТӨЛБӨР ТООЦОО

5.1 Бараа бүтээгдэхүүний нэг бүрийн үнийг гэрээний хавсралтанд заасан үнээр тогтмол нийлүүлнэ.

5.2 Төлбөр тооцоог нэхэмжлэлийн дагуу жилийн эцэст өр авлага үүсгэхгүйгээр санхүүгийн боломжоос хамааран хэсэгчлэн, тооцоо нийлэх зарчмаар нийлүүлэгчийн харилцах дансанд шилжүүлнэ. / Голомт банк дахь 14 15 10 90 95, тоот харилцах данс/ Шилжүүлэгч нь төлбөрийн зориулалт гэсэн хэсэгт хэнээс, хаанаас гэдгээ тодорхойлж байгууллагын нэрээ бичих шаардлагатай.

Зургаа. ТАЛУУДЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

6.1 Талууд хамтран ажиллах хугацаанд олж мэдсэн бизнесийн болон санхүүгийн мэдээ мэдээллийг бусдад дамжуулах, бизнесийн нэр хүндэд хууль бусаар халдахыг хориглоно.

6.2 Талуудын аль нэг нь нөгөө талдаа урьдчилан мэдэгдэлгүйгээр гэрэвдагч этгээдэд эрх, үүргээ шилжүүлэхийг хориглоно.

6.3 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд шаардлагатай гэж үзвэл гэрээний нэг тал үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоох буюу урьдчилан сануулга өгнө.

6.4 Гэрээ байгуулсан аль нэг тал, гэрээний хугацаанд үүргээ гүйцэтгээгүй бол нөгөө талд учирсан хохиролыг нөхөн төлөх үүрэгтэй.

Долоо. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1 Энэхүү гэрээнээс үүдэн гарсан маргааныг талууд эвлэрлийн замаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Үндэсний Арбитр түүний Хянан Шийдвэрлэх дүрмийн дагуу эцэслэн шийдвэрлүүлнэ.

Найм. ГЭРЭЭНИЙ ХУГЦАА ДУУСГАВАР БОЛОХ

8.1 Энэхүү гэрээ талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг, дурэн, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж нэг жилийн хугацаанд ургалжилна.

8.2 Гэрээний хугацаа дуусахад 14 хоногийн дотор аль нэг тал гэрээг цуцлах санал гаргаагүй үүргээ гүйцэтгэснээр байгаа бол дахин нэг жил сунгагдсанд тооцно.

8.3 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс нөгөө талдаа хохирол учруулсан, учрах нь илт байгаа тохиолдолд нэг талын санаачилгаар гэрээг цуцалж болно.

8.4 Талууд харилцан тохиролцож гэрээг хугцаанаас өмнө дуусгавар болгож болно. Ингэхдээ цуцлахыг санаачлагч тал нь сарын өмнө мэдэгдэж албан ёсоор гэрээг цуцалж акт үйлдэнэ.

Ес. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

9.1 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахдаа талууд харилцан тохиролцон бичгээр үйлдэх бөгөөд гэрээний нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

Арав. БУСАД ЗААЛТ

10.1 Гэрээг 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

10.2 Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний Хууль болон бусад хууль тогтоомжийг мөрддөг болно.

Талуудын хаяг

Худалдан авагч:

Хаяг:
Албан тушаал: ААН - В. Раматрэн
Гарын үсэг: [Signature]
Утас:

Худалдагч:

Хаяг: БГД, 8 дугаар хороо 99-51
Утас:
Албан тушаал: Менежер М.Баярцэцэг
Гарын үсэг: [Signature]
Утас: 99094363

Зөвшөөрсөн



1. Раматрэн